

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	7
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .	9
	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
	4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	14
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	16
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	17
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	18
	5. Аудит хийсэн бизнес төлөвлөгөөний биелэлт.....	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



"БӨРТЭ" ТӨААТҮГ-ЫН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ, ХУРАНДАА Б.ЭРХЭМБАЯР
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.25 № 06/591
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "БӨРТЭ" ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Сөрөг санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж "БӨРТЭ" ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "БӨРТЭ" ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


1. Нийт авлагын үлдэгдлийн 95 хувь буюу 60 харилцагчийн 117.3 сая төгрөгийг "Тооцооны үлдэгдлийн баталгаа"-аар баталгаажуулаагүй.
2. Үйлдвэрлэлээс хүлээлгэн өгсөн мастерын баримт, бэлэн бүтээгдэхүүний орлогын баримт, бэлэн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй бүртгэлүүдийг тулган шалгахад нийт 956.7 сая төгрөгөөр зөрүүтэй, анхан шатны баримтгүйгээр бүртгэл хөтөлдөг нь нягтлан бодох бүртгэлийн суурь системийг алдагдуулсан.
3. Дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлагдсан 820.5 сая төгрөгийн өртгийг үндэслэлгүй "Борлуулсан бүтэгдэхүүний өртөг" дансанд хаасан нь 2018 онд тайлагнагдсан борлуулсан бүтэгдэхүүний өртгийн 21.5 хувийг эзэлж байгаа нь тус байгууллагын үр ашиг бодитой илэрхийлэгдээгүй байх эрсдэлтэй.
4. "Бөртэ" ТӨААТҮГ-ын захирлын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/90 тоот тушаалаар хийгдсэн 2018 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалыг тооллогоор 193.0 сая төгрөгийн бараа материалыг хамруулаагүй, тооллогын комиссын дүгнэлтийг баталгаажуулаагүй байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан бараа материалын үлдэгдэл бодитой гэж үзэх үндэслэлгүй байгаа зэрэг нь Санхүүгийн тайлагналын Эрх ба үүрэг, Оршин байгаа, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Топилуулга ба илчлэл тодруулга, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

"БӨРТЭ" ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын ерөнхий захирал, хурандаа Б.Эрхэмбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Бөртэ” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 21-нээс 2019 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Мэдээлэл-Аудит” ХХК-ийн Аудитор А.Гэрэлмаа анхан шатны чанарын хяналт хэрэгжүүлэхээр, Ахлах аудитор Д.Товуудорж, Аудитор Д.Туяа, Аудитор Э.Отгонзаяа, Шинжээч С.Наранцэцэг, Шинжээч Д.Цэрэндорж нар аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг, тодруулгын хамт “Мэдээлэл-Аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар албан бичгээр ирүүлсэн. Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийн 2019 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 118 дугаар бүхий албан бичгээр дахин ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно. Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Бөртэ” ТӨААТҮГ-ын эрхэм зорилго нь “үйлдвэрлэлийн техник, технологийг сайжруулан шинэчилж, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэн, зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэн, санхүү, эдийн засгийн үр ашигтай ажиллан, цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийн чанар, стандартыг сайжруулах” гэж тодорхойлсон байна.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Компанийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай багц хууль
- Татварын тухай багц хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Төрийн албаны тухай
- Зөрчлийн тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай
- Батлан хамгаалах багц хуулиуд

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль эрх зүйн орчны хувьд томоохон өөрчлөлт ороогүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2015 онд боловсруулагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Бөртэ” ТӨААТҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Макс” програм хангамж ашигладаг байна.

“Бөртэ” ТӨААТҮГ дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Дотоод хяналт үр нөлөөгүй байгаад Менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Бөртэ” ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус газрын орлого төлөвлөгддөг ба зардал нь удирдлагын шийдвэрээр гардаг тул нарийвчлан хянаж, эрсдэлтэй гэж үзлээ.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2018 оны Нийт зардал 4,078.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 81.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 10 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Бөртэ” ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Хөрөнгийн дахин үнэлгээгээр “Газар эзэмших эрхийн гэрчилгээ”-тэй газрыг 70.1 сая төгрөгөөр Санхүүгийн тайланд “Барилга байгууламж”-ийн дансанд ангилал буруу бүртгэснийг биет бус хөрөнгөнд,
- Хөрөнгийн дахин үнэлгээ нь Санхүүгийн тайланд 0.3 сая төгрөгийн зөрүүтэй тусгагдсаныг үндсэн хөрөнгө, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансуудад,
- Санхүүгийн тайланд 22.0 сая төгрөгийн цалингийн зардлыг тусгаагүй байсныг борлуулсан бүтээгдхүүний өртөг, ерөнхий болон удирдлагын зардал дансуудад,
- Мөнгөн гүйлгээний тайланг 285.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг авлага, өглөгийн дансуудад залруулга хийсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	2,087.5	
2	Албан шаардлага өгсөн	2	2,325.4	
	Дүн	7	4,412.9	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал: 1

Сонгон шалгаруулалтгүйгээр 1,939.5 сая төгрөгийн бараа, түүхий эд материал худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 “Энэ хуулийн 8.1 дэхь хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Асуудал: 2

Бараа материалд гэнэтийн тооллого хийхэд дансанд бүртгэлгүй 28 боодол буюу хүлээлгэн өгсөн компанийн гэрээний үнээр бодоход 363.8 сая төгрөгийн дижитал даавуу илүү, бэлэн бүтээгдэхүүн нь 5.2 сая төгрөгөөр илүү, үнэ бууруулж худалдах зүйлс 16.9 сая төгрөгөөр дутуу тоологдож, нийт 385.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн дотоод хяналт байхгүй, мөн санхүүгийн тайлагналын оршин байгаа, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, толилуулга ба илчлэл тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа нь тус үйлдвэрийн материал, бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл буруу тайлагнагдсан байх эрсдэл өндөр байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал нь бүтээгдэхүүний өртөг тооцоолол болон борлуулах үнийг үндэслэлтэй тогтоосон эсэх.

2.10. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Удирдах дээд байгууллагаас бизнес төлөвлөгөөгөөр 3,732.0 сая төгрөгийн орлоготой, 3,447.3 сая төгрөгийн зардалтай байхаар баталсан боловч гүйцэтгэлийг хянаагүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар “Бөртэ” ТӨААТҮГ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 141 мэдээлэл байршуулсан байна.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6 зөвлөмжөөс 2 зөвлөмж бүрэн биелсэн, 2 зөвлөмж 50 хувийн биелэлттэй, 2 зөвлөмж огт биелээгүй байгаа нь 50 хувьтай байна. Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

Бүрэн хэрэгжээгүй зөвлөмж: 1

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг бүрдүүлэх зардлын гүйцэтгэлийг “Дуусаагүй үйлдвэрлэл” дансанд хуримтлуулан бүртгэдэг боловч бэлэн болсон бүтээгдэхүүнийг “Бэлэн бүтээгдэхүүн” дансанд шилжүүлэн бүртгэхдээ нэгж бүтээгдэхүүний өртгийг урьдчилан тооцсон “Бүтээгдэхүүний үнэ тогтоох калькуляц”-ын өртгөөр тооцон хааж гүйцэтгэлийг тухай бүр гаргадаггүй нь ББӨ үнэн зөв, тайлант үеийн үеийн үр ашиг бодитой байх боломжгүй байгаад анхаарах,

Бүрэн хэрэгжээгүй зөвлөмж: 2

2016 онд үүссэн Батлан хамгаалах яамнаас авах авлага болох 4.0 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулан авах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг мөрдөн ажиллах,

50 хувийн биелэлттэй зөвлөмж: 3

2015 оноос эхлэн нягтлан бодох бүртгэлдээ ашиглаж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын онцлогийг тусгаагүй, СТОУС-ын шаардлага хангахгүй гэсэн зөвлөмжийн дагуу “Бодь тусгал-Аудит” ХХК-тай гэрээ байгуулан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг төсөл байдлаар хийлгэн 50 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

50 хувийн биелэлттэй зөвлөмж: 4

Нягтлан бодох бүртгэлдээ “Инфо систем” ХХК-ийн МАКС програмыг 2000 оноос эхлэн ашиглаж, 2013 болон 2015 онуудад сайжруулалт хийсэн боловч бүтээгдэхүүний өртөг тооцох функцгүй, үйлдвэрлэл эрхэлдэг тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна гэсэн зөвлөмжийн дагуу бүртгэлийн програм хангамжийг 2019 оны 01 дүгээр сараас шинэчлэхээр “Интерактив Би Ай” ХХК-тай гэрээ байгуулан 9.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Бөртэ” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав. Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Нийт авлагын үлдэгдлийн 95 хувь буюу 60 харилцагчийн 117.3 сая төгрөгийг "Тооцооны үлдэгдлийн баталгаа"-аар баталгаажуулаагүй.

3.1.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” батламж мэдэгдэл зөрчигдөх
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг мөрдөх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид тооцоо нийлсэн актыг үйлдэнэ. Авлага, өглөг хариуцсан нягтлан ажлаасаа гарсан, ерөнхий нягтлан шинээр ажилд орсон тул бүрэн баталгаажуулж амжаагүй.

3.2 Дээд шатны хяналт

3.2.1 Илрүүлэлт

"Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ" -ний тайланг Үнэлгээний ажлын тэмдэглэл хөтлөж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар баталгаажуулаагүй.

3.2.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” батламж мэдэгдэл зөрчигдөх
- МУ-ын ЗГ-ын "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 193 дугаар тогтоол зөрчигдөх,
- ТӨБҮГ-ын "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 273 дугаар тогтоол зөрчигдөх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

МУ-ын ЗГ-ын "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 193 дугаар тогтоол зөрчигдөх, ТӨБҮГ-ын "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 273 дугаар тогтоолыг мөрдөн ажиллах,

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2019 оны 04 дүгээр сарын 30-ний дотор баталгаажуулж өгнө.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт

Загвар, гүйцэтгэлийн цехээс бэлэн болсон бүтээгдэхүүнийг бэлэн бүтээгдэхүүний няравын орлогын баримт, санхүүгийн програмын бэлэн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй бүртгэлүүдийг тулган шалгахад няравын орлогын баримтгүй 363.7 сая төгрөг, дэлгэрэнгүй бүртгэл болон няравын орлогын баримт хоорондоо 29.4 сая төгрөгийн зөрүүтэй, үйлдвэрээс бэлэн бүтээгдэхүүний няравт хүлээлгэж өгсөн баримт, няравын хүлээн авсан орлогын баримт 563.6 сая төгрөг, нийт 956.7 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй байх эрсдэлтэй байна. Анхан шатны баримт байхгүйгээр бүртгэл хөтөлдөг нь нягтлан бодох бүртгэлийн суурь системийг алдагдуулсан, Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавигдах удирдах дээд байгууллагын хяналт, Гүйцэтгэх удирдлагын болон Санхүүгийн дотоод хяналтын систем бүрэн алдагдсан, мөн санхүүгийн ажилтануудын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ажлын дадлага туршлага дутмаг байгаа зэргээс шалтгаалж байна.

3.3.2 Эрсдэл

- Санхүүгийн тайлагналын “оршин байх”, “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх”, “тохиолдсон байх”, “толилуулга ба илчлэл”, “үнэн зөв байдал” зэрэг бүх батлаж мэдэгдлийг хангахгүй байх
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,
- Сангийн сайдын 2017 оны 347 дугаар "Маягт, заавар батлах тухай" тушаал зөрчигдөх,

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар "Маягт, заавар батлах тухай" тушаалын дагуу анхан шатны баримт бүртгэлийг хөтөлж байх, Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, цех тасаг, шат дажлагад тавигдах дотоод хяналтыг сайжруулах, санхүүгийн ажилтануудын ур чадварыг дээшлүүлэх, Удирдах дээд байгууллагаас хяналт тавих,

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Нягтлан бодогчдын хүрэлцээ муу тул хяналт сулардаг. Цаашид анхаарч ажиллана.

3.4 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг данс

3.4.1 Илрүүлэлт

Дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлагдсан 820.5 сая төгрөгийн өртгийг үндэслэлгүй ББӨ дансанд хаасан нь 2018 онд тайлагнагдсан ББӨ-ийн 21.5 хувийг эзэлж байна.

3.4.2 Эрсдэл

- Санхүүгийн тайлагналын “оршин байх”, “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” зэрэг батлаж мэдэгдлийг хангахгүй байх
- Үйл ажиллагааны үр дүн буруу илэрхийлэгдэх,

3.4.3 Өгсөн зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах
- Дамжлага хоорондын бүртгэл өртөг, үнэ тооцооллыг дахин хийж баталгаажуулж мөрдөх,

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Манайх дуусаагүй үйлдвэрлэлд ТЭМ, Хөдөлмөрийн зардал, ҮНЗ-ийг бодит өртгөөр нь бүртгэж, дуусаагүй үйлдвэрлэлээс калкуляцийн өртгөөр бэлэн бүтээгдэхүүний дансанд хааж бүртгэдгээс зөрүү үүсдэг. Энэ зөрүүг тооллогын дүнг үндэслэн өртөгт залруулга хийж бүртгэдэг. Бүтээгдэхүүн тус бүрээр бодит өртөг, калкуляцийн зөрүүг тооцож чадахгүй байгаа.

3.5 Балансын данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт

“Бөртэ”ТӨААТҮГ-ын 2018-11-27 өдрийн захирлын А/90 тоот тушаалаар хийгдсэн 2018 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалыг тооллогоор 193.0 сая төгрөгийн хөрөнгийг хамруулаагүй, “Тооллогын комиссын дүгнэлт”-ийг баталгаажуулаагүй байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан бараа материалын үлдэгдэл бодитой гэж үзэх үндэслэлгүй байна.

3.5.2 Эрсдэл

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх
- Санхүүгийн тайлагналын “оршин байх”, “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” зэрэг батлаж мэдэгдлийг хангахгүй байх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг мөрдөх

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүн хүчний хүрэлцээгүйгээс тооллогыг бүрэн хийж чадаагүй. Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2017	12/31/2018
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	356,570,519.72	79,791,256.70
1.1.2	Дансны авлага	47,804,700.00	123,042,230.34
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	12,935,855.96	17,930,276.03
1.1.4	Бусад авлага	8,873,872.18	
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,987,204,039.54	1,847,684,615.45
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	143,052,103.92	88,994,838.43
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	27,475,000.00	26,880,000.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,583,916,091.32	2,184,323,216.95
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	478,699,868.52	1,060,877,534.79
1.2.2	Биет бус хөрөнгө	1,088,350.00	71,207,240.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	479,788,218.52	1,132,084,774.79
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,063,704,309.83	3,316,407,991.74
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		239,123,273.19
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	1,639,362.78	201,368.14
2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.8	Урьдчилж орсон орлого	359,238,097.66	273,291,527.22
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	360,877,460.44	512,616,168.55
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	360,877,460.44	512,616,168.55
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	581,776,709.35	581,776,709.35
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		667,886,485.36
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		70,118,900.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,121,050,140.04	1,484,009,728.48
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,702,826,849.39	2,803,791,823.19
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,063,704,309.83	3,316,407,991.74

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,717,990,021.79	3,418,676,232.45
2	Борлуулалтын өртөг	4,384,000,028.19	3,837,640,757.19
3	Нийт ашиг(алдагдал)	333,989,993.60	-418,964,524.74
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	3,699,810.85	2,266,353.86
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	22,030,785.91	20,279,972.29
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	132,221,548.72	138,195,451.15
11	Санхүүгийн зардал		89,762,433.47
12	Бусад зардал		13,261,674.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		798,714.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	-119,729,914.14	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	107,769,127.50	-636,839,043.21
19	Орлогын татварын зардал	22,749,904.16	201,368.35
20	Татварын дараах ашиг (алдагдал)	85,019,223.34	-637,040,411.56
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	85,019,223.34	-637,040,411.56
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	85,019,223.34	-637,040,411.56
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	108,092,400.00					473,684,309.35	2,036,030,916.70	2,617,807,626.05
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл	108,092,400.00					473,684,309.35	2,036,030,916.70	2,617,807,626.05
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							85,019,223.34	85,019,223.34
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт	473,684,309.35					473,684,309.35		
7	Зарласан ногдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	581,776,709.35						2,121,050,140.04	2,702,826,849.39
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
11	Залруулсан үлдэгдэл	581,776,709.35						2,121,050,140.04	2,702,826,849.39
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							-637,040,411.56	-637,040,411.56
13	Бусад дэлгэрэнгүй орлого								-
14	Өмчид гарсан өөрчлөлт						70,118,900.00		70,118,900.00
15	Зарласан ногдол ашиг								
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				667,886,485.16				667,886,485.16
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	581,776,709.35			667,886,485.16		70,118,900.00	1,484,009,728.48	2,803,791,822.99

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,167,390,660.54	4,258,281,815.28
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,158,818,908.69	3,924,618,718.01
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		34,020,336.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		4,087,635.85
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	8,571,751.85	295,555,125.42
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,034,196,877.77	4,537,327,432.16
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,423,892,781.00	1,263,673,240.93
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	349,197,942.78	341,112,450.31
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,597,137,799.45	2,042,975,189.94
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	50,444,873.12	55,374,819.71
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,751,800.00	7,957,738.57
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	529,587,871.42	332,194,353.01
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	81,183,810.00	494,039,639.69
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	133,193,782.77	279,045,616.88
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		2,266,353.86
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		

2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		2,266,353.86
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-55,872,072.73	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-55,872,072.73	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-55,872,072.73	2,266,353.86
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		200,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		200,000,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		200,000,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		200,000,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	77,321,710.04	-276,779,263.02
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	279,248,809.68	356,570,519.72
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	356,570,519.72	79,791,256.70

5. Аудит хийсэн БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

ДД	Дансны нэр	2018.12.31		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ		
1. ОРЛОГО					
1.1	Үндсэн бүтээгдэхүүний борлуулалтын орлого	3,682,000.00	3,303,161.30	378,838.70	90%
1.2	Туслах аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалт				
1.3	Дэлгүүрийн борлуулалтын орлого		92,968.61		
1.4	Бусад орлого	50,000.00			0%
1.5	Үйл ажиллагааны бус орлого		20,279.97		
1.6	Харилцах дансны хүүгийн орлого		2,266.35		
ОРЛОГЫН ДҮН		3,732,000.00	3,418,676.23	313,323.77	92%
2. ЗАРЛАГА					
Үйлдвэрлэлийн шууд зардал		2,807,572.00	3,201,498.80		114%
	Үйлдвэрлэл материалын зардал/Шууд материал	1,707,072.00	1,781,079.18	(74,007.18)	104%
	Хийснээр олгох цалин/Шууд хөдөлмөр	1,100,500.00	1,420,419.62	(319,919.62)	129%
3. ҮНЗ, удирдлагын зардал		639,724.04	854,016.47	(214,292.43)	133%
2.1	Цалин	73,892.60	58,087.75	15,804.85	79%
2.2	Нэмэгдэл цалин	57,844.80		57,844.80	0%
2.3	Нийгмийн даатгалын зардал	129,183.18	184,816.21	(55,633.03)	143%
2.4	Усны зардал	5,563.37	5,696.25	(132.88)	102%
2.5	Дулааны зардал	14,722.58	14,470.13	252.45	98%
2.6	Цахилгааны зардал	29,764.79	28,119.91	1,644.88	94%
2.7	Холбооны зардал	5,029.18	4,081.14	948.04	81%
2.8	Унааны зардал	68,688.00	59,410.15	9,277.85	86%
2.9	Хоолны зардал	51,675.00	61,868.31	(10,193.31)	120%
2.10	Цэвэрлэгээний зардал	4,725.00	4,370.76	354.24	93%
2.11	Урсгал засварын зардал	10,551.80	9,547.16	1,004.64	90%
2.12	Тоног төхөөрөмж сэлбэг хэрэгслийн зардал	22,231.00	15,863.83	6,367.17	71%
2.13	Томилолтын зардал	13,004.04	7,872.32	5,131.72	61%
2.14	Сурталчилгааны зардал	2,944.30			0%

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

				2,944.30	
2.15	Сургалтын зардал	15,000.00	9,962.03	5,037.97	66%
2.16	Бичиг хэргийн зардал	8,000.00	15,445.38	(7,445.38)	193%
2.17	Шатахуун, тослох материалын зардал	5,379.20	8,189.28	(2,810.08)	152%
2.18	Элэгдлийн зардал	90,970.00	89,928.99	1,041.01	99%
2.19	Хөдөлмөр хамгааллын зардал	1,493.40	759.64	733.76	51%
2.20	Хэвлэл захиалгын зардал	479.80	465.90	13.90	97%
2.21	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2,973.40	3,480.96	(507.56)	117%
2.22	Газрын төлбөр	570.40	690.50	(120.10)	121%
2.23	Аж ахуй, хангамжийн зардал	21,380.00	18,805.82	2,574.18	88%
2.24	Авто сэлбэгийн зардал	1,203.20	1,094.70	108.50	91%
2.25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил		12,841.11	(12,841.11)	
2.26	Бусад зардал	2,455.00	238,148.24	(235,693.24)	9701%
	Дүн			-	
	Татвар төлөхийн өмнөх ашиг	284,703.96	(636,839.04)	921,543.00	-224%
	ОАТ-ын зардал	28,473.00	201.37	28,271.63	1%
	Татварын дараах зардал	256,230.96	(637,040.41)	893,271.37	-249%
4	Нийгэм ахуй халамж үйлчилгээ			-	
	Тэмдэглэлт арга хэмжээ, үйл ажилл			-	
	Уулзалт зөвлөгөөн, ҮАБЗ			-	
	Бусад	69,000.00		69,000.00	0%
	Хөгжлийн санд Ногдол ашиг	50,000.00		50,000.00	0%
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	119,000.00	-	119,000.00	0%
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	137,230.96	(637,040.41)	774,271.37	-464%
	Татварын өмнөх ашиг/алдагдал			-	
5	ОАТ зардал			-	
	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ/АЛДАГДАЛ	<u>137,230.96</u>	(637,040.41)	774,271.37	-464%
	Ажиллагсдын тоо	181	174	7.00	96%
6	Хийснээр цалинжигч	130	146	(16.00)	112%
	Тогтмол цалинжигч	51	28	23.00	55%

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2019.03.15			САГ-2019/27/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Бөртэ” ТӨААТҮГ		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Нийт авлагын үлдэгдлийн 95 хувь буюу 60 харилцагчийн 117.3 сая төгрөгийг "Тооцооны үлдэгдлийн баталгаа"-аар баталгаажуулаагүй.	117.3	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Дашдулам
2	"Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ" - ний тайланг Үнэлгээний ажлын тэмдэглэл хөтлөж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар баталгаажуулаагүй.	-	Зөвлөмж	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Эрхэмбаяр, Ц.Дашдулам
3	Сонгон шалгаруулалтгүйгээр 1,939.5 сая төгрөгийн бараа, түүхий эд материал худалдан авсан.	1,939.5	Албан шаардлага	Захирал	Б.Эрхэмбаяр
4	Загвар, гүйцэтгэлийн цехээс бэлэн болсон бүтээгдэхүүнийг бэлэн бүтээгдэхүүний нярвын орлогын баримт, санхүүгийн програмын бэлэн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй бүртгэлүүдийг тулган шалгахад нийт 956.7 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй байх эрсдэлтэй байна. Анхан шатны баримт байхгүйгээр	956.7	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Дашдулам

	бүртгэл хөтөлдөг нь нягтлан бодох бүртгэлийн суурь системийг алдагдуулсан.				
5	Бараа материалд гэнэтийн тооллого хийхэд дансанд бүртгэлгүй 28 боодол буюу хүлээлгэн өгсөн компанийн гэрээний үнээр бодоход 363.8 сая төгрөгийн дижитал даавуу илүү, бэлэн бүтээгдэхүүн нь 5.2 сая төгрөгөөр илүү, үнэ бууруулж худалдах зүйлс 16.9 сая төгрөгөөр дутуу тоологдож, нийт 385.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн.	385.9	Албан шаардлага	Захирал	Б.Эрхэмбаяр
6	Дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлагдсан 820.5 сая төгрөгийн өртгийг үндэслэлгүй ББӨ дансанд хаасан нь 2018 онд тайлагнагдсан ББӨ-ийн 21.5 хувийг эзэлж байгаа нь тус байгууллагын үр ашиг бодитой илэрхийлэгдээгүй байх эрсдэлтэй байна.	820.5	Зөвлөмж	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Эрхэмбаяр, Ц.Дашдулам
7	"Бөртэ"ТӨААТҮГ-ын 2018-11-27 өдрийн захирлын А/90 тоот тушаалаар хийгдсэн 2018 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалыг тооллогоор нийт 193.0 сая төгрөгийн хөрөнгийг хамруулаагүй, Тооллогын комиссын дүгнэлтийг баталгаажуулаагүй байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан бараа материалын үлдэгдэл бодитой гэж үзэх үндэслэлгүй.	193.0	Зөвлөмж	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Эрхэмбаяр, Ц.Дашдулам
	Дүн	4,412.9			